

**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 8 гишүүн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчаас Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколоор Оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор бие даасан, хараат бус Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулах үүрэг хүлээсний дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төсвийг бүрэн хараат бус байхаар нэг мөр зохицуулах, чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэхэд бусад байгууллага, албан тушаалтан шууд нөлөөлөх эрсдэлтэй байдлыг хязгаарлах, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн тангараг өргөх, шаардлага бичих зэрэг эрх зүйн зохицуулалтыг тусган хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар шинээр зардал гарахгүй, асуудал хариуцсан байгууллагын үндсэн төсвийн хүрээнд шийдвэрлэх боломжтой гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг www.d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Засгийн газрын хуралдаанаар уг хуулийн төслийг дэмжээгүй талаар, мөн одоогийн тогтолцоогоор үргэлжлүүлэн ажиллах боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа байгууллага, албан тушаалтнууд үйл ажиллагаагаа уялдуулж ажиллах шаардлагатай талаар тус тус санал хэлсэн болно.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Д.ЦОГТБААТАР